

ӨНДӨРХААН ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 12 сарын 21-ний өдөр

Дугаар №1

Улаанбаатар хот

Өндөрхаан ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2021 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 11:00 цагаас <https://live.ard.mn/> сайтаар дамжуулан хурал эхлэв.

Б.Гантулга: Хувьцаа эзэмшигч та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Өнөөдөр Өндөрхаан ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал болж байна. Энэхүү хуралд Өндөрхаан ХК-ийн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч болох Г.Цогбадрах, О.Амарболд, Б.Гантулга, Г.Уянга, Б.Оюутцэцэн, Г.Сүхбаатар, Т.Билэгсайхан, Г.Бурмаа, Д.Хулан, мөн Өндөрхаан ХК-ийн гүйцэтгэх захирал О.Амарболд, хурал зохион байгуулах комиссын дарга Г.Долгорсүрэн, тооллогын комиссын дарга С.Намжилмаа болон Өндөрхаан ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ц.Анударь нар болон хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл оролцохоор ирсэн байна.

Хурал эхлэхийн өмнө та бүхэнд хурлын дэгийн дагуу хурлаар хэлэлцэх асуудлыг товч танилцуулав. Уг хурлаар компанийн оноосон нэр өөрчлөх, компанийн хувьцааны үсгэн код өөрчлөх, компанийн бүртгэлтэй хаягийг өөрчлөх, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ шинээр авах, компанийн зарласан хувьцааны тоог өөрчлөх, нэмж хувьцаа гаргах, түүний нөхцөл, нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байх, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах, компанийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлд өөрчлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн найруулга батлах, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг хугацаанаас өмнө чөлөөлөх, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох болон бусад асуудлыг хэлэлцэх болно. Хувьцаа эзэмшигчдийн зүгээс хэлэлцэх асуудалд асуулт санал байна уу?

Хэрэв хуралд оролцогчид болон хувьцаа эзэмшигчдээс маань асуулт байхгүй бол хурлаа эхэлцгээе.

Г.Долгорсүрэн: Хурлын ирцийг тооллогын комиссын дарга танилцуулна уу.

С.Намжилмаа: Хувьцаа эзэмшигчдэд энэ өдрийн мэнд хүргэе. Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.1, 67.3.2, 67.3.8 болон 68.4 дэх хэсгийг үндэслэн тогтооход компанийн зарласан 111,879 ширхэг энгийн хувьцаа эзэмшигчдийн 91,314 буюу 81.6 хувь нь хуралд оролцсоноор өнөөдрийн хувьцаа эзэмшигчийн хурал хүчин төгөлдөр болж байна.

Б.Гантулга: За ойлголоо. Гүйцэтгэх захирал О.Амарболд компанийн танилцуулна уу.

О.Амарболд: Хувьцаа эзэмшигч та бүхэнд Өндөрхаан ХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөх талаар хурлын мэдэгдэлд хүргүүлсэн билээ. Үүнтэй холбоотойгоор дэлхийн болон Монгол улсын даатгалын зах зээл болон Өндөрхаан ХК-ийн товч танилцуулгын талаар мэдээлэл хүргэе.

Дэлхийн даатгалын салбар 2020 онд 6,287,044 сая.долларын даатгалын хураамжийн орлогыг бүрдүүлсэн ба үүнээс урт хугацааны даатгагчид 2,797,437 сая.долларыг бүрдүүлсэн байна. Танилцуулга дээр харагдаж буй даатгалын хураамжийн орлогын өсөлтийн төсөөлөл нь дэвшилтэт, хөгжиж буй, дэлхий дахинд, Хятад улсад, Хөгжиж буй улсуудыг хооронд нь харьцуулан, 2020 оноос эхлэн 2022 оны санхүүгийн жил хүртэлх амьдралын болон ердийн даатгалын хураамжийн орлогын өсөлтийн төсөөллийг харьцуулан харуулж байна.

Өндөрхаан ХК-ийн хувьд 1992 онд Хэнтий аймагт үр тариа болон бусад ургамал тариалалт, үр тарианы гурил үйлдвэрлэл, хүнсний ногоо, үрслэг тариалалт, мал аж ахуй чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар байгуулагдсан.

Компанийн ногдол ашгийн тухай

Өндөрхаан ХК нь 2020 онд үйл ажиллагаа явуулаагүй тул 2021 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн №1 тоот тогтоолоор ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэр гаргасан. Мөн 2021 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 111,879 ширхэг энгийн хувьцааг 304 хүн эзэмшиж байна.

Б.Гантулга: Компанийн танилцуулга хийсэн гүйцэтгэх захиралд баярлалаа. Үргэлжлүүлэн хэлэлцэх асуудлуудыг ярилцах нь зүйтэй болов уу. Хурлыг зохион байгуулагч Г.Долгорсүрэн хэлэлцэх асуудлуудыг танилцуулна уу.

Г.Долгорсүрэн: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Хэлэлцэх асуудал №1. Компанийн оноосон нэр өөрчлөх тухай

Өндөрхаан ХК-ийн нэрийг өөрчилж, Ард Лайф ХК болгох тухай

Хэлэлцсэн нь: Нэмэлт санал байхгүй.

Хэлэлцэх асуудал №2. Компанийн хувьцааны үсгэн код өөрчлөх тухай

Компанийн хувьцааны Монголын хөрөнгийн бирж дээрх үсгэн код болох ONH-г өөрчилж, LIFE болгох тухай

Хэлэлцсэн нь: Нэмэлт санал байхгүй.

Хэлэлцэх асуудал №3. Компанийн бүртгэлтэй хаягийг өөрчлөх, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ шинээр авах тухай

Компанийн одоогийн байгаа хаяг нь Хэнтий, Хэрлэн, 5-р баг Өндөрхаан 01 ба Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Чингисийн талбай-2, Централ Тауэр, 17 давхарт шилжүүлэх тухай.

Хэлэлцсэн нь: Нэмэлт санал байхгүй.

Хэлэлцэх асуудал №4. Компанийн зарласан хувьцааны тоог өөрчлөх, нэмж хувьцаа гаргах, түүний нөхцөл

Компанийн үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөн зохион байгуулах зорилгоор зарласан болон гаргасан хувьцааны тоог нэмэгдүүлэх тухай.

Хэлэлцсэн нь: Нэмэлт санал байхгүй.

Хэлэлцэх асуудал №5. Нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байх тухай

Хэлэлцсэн нь: Нэмэлт санал байхгүй.

Хэлэлцэх асуудал №6. Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай

Хувьцаа эзэмшигчид маань <https://live.ard.mn/> сайтаар дамжуулан хурлын дэлгэрэнгүй мэдээлэлтэй танилцах боломжтой ба хэлэлцэх асуудлуудаар 11:45 цагаас 12:00 цагийн хооронд саналаа өгөх боломжтой байгаа мөн асуулт, хариулт байвал тухай бүрд нь асуух боломжтой.

Хэлэлцсэн нь: Нэмэлт санал байхгүй.

Хэлэлцэх асуудал №7. Компанийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлд өөрчлөлт оруулах тухай

Өндөрхаан ХК нь үр тариа болон бусад ургамал тариалалт, үр тарианы гурил үйлдвэрлэл, хүнсний ногоо, үрслэг тариалалт, мал аж ахуй чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ба энэхүү үйл ажиллагааг урт хугацааны даатгалын болон менежментийн зөвлөх үйл ажиллагаа эрхлэх тухай болгож өөрчлөх асуудал байна.

Хэлэлцэх асуудал №8. Дүрмийн шинэчилсэн найруулга батлах тухай

Хэлэлцсэн нь: Нэмэлт санал байхгүй

Хэлэлцэх асуудал №9. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг хугацаанаас өмнө чөлөөлөх тухай

Хэлэлцсэн нь: Нэмэлт санал байхгүй

Б.Гантулга: Эхний 9 асуудлыг танилцуулсанд баярлалаа. Хувьцаа эзэмшигчдэд хэлэлцэх асуудлуудын дэлгэрэнгүй мэдээллийг хурлын зар хүргэх үед хүргэсэн тул та бүхэн мэдээлэлтэй байгаа гэж бодож байна. Гэхдээ та бүхэнд асуулт байгаа болов уу? Байхгүй бол цааш үргэлжлүүлье.

Хэлэлцэх асуудал №10. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Б.Гантулга: Төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшиж буй гишүүд та бүхнийг өөрийгөө танилцуулахыг хүсэж байна.

/Төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшиж буй гишүүд өөрсдийгөө танилцуулав/

Хэлэлцсэн нь: Нэмэлт санал байхгүй

Б.Гантулга: Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнээр нэр дэвшиж буй та бүхэнд баярлалаа мөн амжилт хүсье. Хувьцаа эзэмшигчид та бүхэн санал хураах хэсэгт мөн саналаа өгч болох байгаа. Хувьцаа эзэмшигчээс ирсэн саналыг танилцуулъя.

Хувьцаа эзэмшигчдээс ирсэн санал:

1. Хувьцаа эзэмшигч Ө.Ашхүү : Хувьцааны үнэ сүүлийн үед их өсч байна. Иймээс хэлэлцэ асуудал №4 дэх асуудал дээр гаргасан хувьцааны тоо, гаргах үнэ зэргийг тогтоох эрхийг ТУЗ-д олгох саналтай байна.

Г.Долгорсүрэн: Хувьцаа эзэмшигч Ө.Ашхүүгийн өгсөн саналыг бид тогтоолын төсөлд тусгая.

Б.Гантулга: Хувьцаа эзэмшигчдээс өөр санал байгаа бол саналаа хэлнэ үү.

2. Хувьцаа эзэмшигч Б.Батаа: Та бүхэнд ажлын амжилт хүсье. Мөн цаашдын компанийн үйл ажиллагааг улам өргөжүүлээрэй.

3. Хувьцаа эзэмшигч Ө.Ашхүү: Хэлэлцэх асуудал №6 дах сонирхлын зөрчилтэй хэлцлийн тогтооллын төсөлд өөрчлөлт оруулах саналтай байна.

4. Хувьцаа эзэмшигч Ө.Ашхүү: Хэлэлцэх асуудал №7 дах асуудалд үйл ажиллагаатай холбоотойгоор тогтоолын төсөлд санал өгмөөр байна.

Г.Долгорсүрэн: Ингээд хувьцаа эзэмшигчдээс ирсэн бүх саналыг танилцууллаа.

Б.Гантулга: Саналууд нь бичгээр ирж байна уу?

Г.Долгорсүрэн: Уг саналууд нь <https://live.ard.mn/>- зэр дамжуулан ирж байгаа ба хувьцаа эзэмшигчид санал хураалтаа өгөх, хурлын материалтай танилцах болон асуулт хариулт явуулах боломжтой байгаа. Энэ жишгээр хувьцаа эзэмшигчид маань хурлыг шууд үзэн санал хүсэлтээ асуулт санал хэсэгт шууд бичиж бидэнд ирүүлж байна. Санал хураалт 11:45 цагаас 12:00 цагийн хооронд болох ба энэ хугацаанд компанийн удирдлага болон төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшигчдэд ярилцах зүйлс байгаа болов уу?

Б.Гантулга: Хурлын дэгийн дагуу 11:45 цаг хүртэл хувьцаа эзэмшигч Ө.Ашхүүг саналаа танилцуулахыг хүлээе. Санал танилцуулагдсаны дараа хэлэлцэх асуудлууд дээр санал хураалтыг эхлүүлцгээе.

Г.Долгорсүрэн: Та бүхэнд хэлэлцсэн асуудлууд тус бүрд хувьцаа эзэмшигчдээс ирсэн саналыг тусган хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тогтоолын төслүүдийг танилцуулъя.

/Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тогтоолын төслүүдийг танилцуулав/

Б.Гантулга: Тогтоолын төсөл №4 дээр Компанийн зарласан хувьцааны тоог 3,571,429 ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлж нэг бүр нь 1,680 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 3,683,308 ширхэг энгийн хувьцаатай байхаар тогтоолын төсөл гарч байна.

Г.Долгорсүрэн: Энэхүү тогтоолын төсөлд хувьцаа эзэмшигчдээс ирсэн саналуудыг тусгасан байна.

Б.Гантулга: Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдэдээ баярлалаа. Хэлэлцсэн асуудлууд дээр та бүхэн 11:48 цагаас 12:03 цаг хүртэл саналаа <https://live.ard.mn/>- зэр санал хураалт хэсгээр дамжуулан өгнө үү.

Б.Гантулга: Өндөрхаан ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал амжилттай болж байна. Өнөөдөр нийт арван хэлэлцэх асуудлын хүрээнд хуралдаж, санал хураалт дууслаа. Санал хураалтын дүнг тооллогын комиссын дарга С.Намжилмаа танилцуулна уу.

С.Намжилмаа: Хэлэлцэх асуудал бүрээр тооллогын дүнг та бүхэнд танилцуулъя.

1. Хэлэлцэх асуудал №1. Компанийн оноосон нэр өөрчлөх тухай санал хураалтад 91,314 ширхэг хувьцаа буюу 81.6 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноос:

1.1 Зөвшөөрсөн 91,313 ширхэг буюу 99.998%

1.2 Татгалзсан 0 ширхэг 0%

1.3 Түдгэлзсэн 0 ширхэг 0% байх тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

2. Компанийн хувьцааны үсгэн код өөрчлөх тухай санал хураалтад 91,314 ширхэг хувьцаа буюу 81.6 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноос:

2.1 Зөвшөөрсөн 91,313 ширхэг буюу 99.998%

2.2 Татгалзсан 0 ширхэг 0%

2.3 Түдгэлзсэн 0 ширхэг 0% байх тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

3. Хэлэлцэх асуудал №3. Компанийн бүртгэлтэй хаягийг өөрчлөх, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ шинээр авах тухай санал хураалтад 91,314 ширхэг хувьцаа буюу 81.6 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноос:

3.1 Зөвшөөрсөн 91,313 ширхэг буюу 99.998%

3.2 Татгалзсан 0 ширхэг 0%

3.3 Түдгэлзсэн 0 ширхэг 0% байх тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

4. Компанийн зарласан хувьцааны тоог өөрчлөх, нэмж хувьцаа гаргах, түүний нөхцөлийг батлах тухай санал хураалтад 91,314 ширхэг хувьцаа буюу 81.6 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноос:

4.1 Зөвшөөрсөн 91,313 ширхэг буюу 99.998%

4.2 Татгалзсан 0 ширхэг 0%

4.3 Түдгэлзсэн 0 ширхэг 0% байх тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

5. Нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байх тухай санал хураалтад 91,314 ширхэг хувьцаа буюу 81.6 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноос:

5.1 Зөвшөөрсөн 91,313 ширхэг буюу 99.998%

5.2 Татгалзсан 0 ширхэг 0%

5.3 Түдгэлзсэн 0 ширхэг 0% байх тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

6. Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай санал хураалтад 91,314 ширхэг хувьцаа буюу 81.6 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноос:

6.1 Зөвшөөрсөн 91,313 ширхэг буюу 99.998%

6.2 Татгалзсан 0 ширхэг 0%

6.3 Түдгэлзсэн 0 ширхэг 0% байх тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

7. Компанийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлд өөрчлөлт оруулах тухай санал хураалтад 91,314 ширхэг хувьцаа буюу 81.6 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноос:

7.1 Зөвшөөрсөн 91,313 ширхэг буюу 99.998%

7.2 Татгалзсан 0 ширхэг 0%

7.3 Түдгэлзсэн 0 ширхэг 0% байх тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

8. Дүрмийн шинэчилсэн найруулга батлах тухай тухай санал хураалтад 91,314 ширхэг хувьцаа буюу 81.6 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноос:

8.1 Зөвшөөрсөн 91,313 ширхэг буюу 99.998%

8.2 Татгалзсан 0 ширхэг 0%

8.3 Түдгэлзсэн 0 ширхэг 0% байх тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

9. Төлөөлөн удирдах зөвлөлийг гишүүдийг хугацаанаас өмнө чөлөөлөх тухай санал хураалтад 91,314 ширхэг хувьцаа буюу 81.6 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноос:

9.1 Зөвшөөрсөн 91,313 ширхэг буюу 99.998%

9.2 Татгалзсан 0 ширхэг 0%

9.3 Түдгэлзсэн 0 ширхэг 0% байх тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

10. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай санал хураалтад 91,314 ширхэг хувьцаа буюу 81.6 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноос доорх хүснэгтэд зааснаар

№	ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн овог нэр	Саналын тоо
1	Галбадрах Цогбадрах	100,000 ширхэг буюу 109.5% санал
2	Отгонбаяр Амарболд	95,000 ширхэг буюу 104% санал
3	Булган Гантулга	100,000 ширхэг буюу 109.5% санал
4	Галням Уянга	95,000 ширхэг буюу 104% санал
5	Баярсайхан Оюутцэцэн	85,000 ширхэг буюу 93.08% санал
6	Гүррагчаа Сүхбаатар	85,000 ширхэг буюу 93.08% санал

7	Тогмид Билэгсайхан	85,000 ширхэг буюу 93.08% санал
8	Галаа Бурмаа	85,000 ширхэг буюу 93.08% санал
9	Даваадорж Хулан	84,608 ширхэг буюу 92.6% санал

байх тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

Б.Гантулга: Тооллогын комиссын дарга С.Намжилмаад баярлалаа. Өндөрхаан ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал амжилттай өндөрлөж, хувьцаа эзэмшигчдийн саналыг авч, нийт арван асуудлын хүрээнд хэлэлцэж шийдвэрлэв. Хуралдаа идэвхтэй оролцсон хувьцаа эзэмшигчид та бүхэнд баярлалаа. Ингээд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хаасныг мэдэгдэж байна.

Хурал 12 цаг 10 минутад дуусаав.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

ХУРЛЫН ДАРГА

Хурлын тэмдэглэлийг хөтөлсөн:

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Б.ГАНТУЛГА

Ц.АНУДАРЬ

